


МОНГОЛ-ОРОСЫН ХУДАЛДААНЫ АСУУДЛЫГ ШИЙДЭХ БОЛОМЖ, ХЭРЭГЦЭЭ

А.Даваасүрэн*

I. Монгол-Оросын худалдааг өнөөгийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх боломж, хэрэгцээ

1991 оныг хүртэл Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтэнд ЗХУ-ын эзлэх хувийн жин 80 орчим хувь байсан боловч түүнээс хойш тогтмол буурсан байна. Харин тус оронтой хийх гадаад худалдааны нийт эргэлтийн үнийн дүн 2008 онд 1.3 тэрбум долларт хүрч анх удаа 1990 оны үеийн 1,23 тэрбум ам.долларын түвшингээс давсан. 2009 оны дэлхийн эдийн засгийн хямралд хоёр улс хоёулаа өртөж, дотоод зах зээл дээрхи эрэлт эрс унаж, валютын ханш буурсанаар алт валютын нөөцийн хэмжээ багасаж импортын төлбөрийг төлөх чадамж нь буурсан ч 2010 оноос хурдан сэргэж хоёр улсын худалдааны эргэлт 1169.3 тэрбум долларт хүрч эдийн засгийн уналтаас гарч сэргэх замдаа ороод явж байна. Зураг 1-ээс харна уу.

Зураг 1.



Хоёр орны худалдааны эргэлт буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үздэг. Үүнд:

1. 1991 оны 4 сард Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн (ЭЗХТЗ) үйл ажиллагаа бүрэн зогссоноор түүний бүрэлдэхүүнд багтаж байсан социалист системийн орнуудын бараа бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадваргүй болсон

* А.Даваасүрэн - ОУСХ-гийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) профессор

- учир эдгээр орнуудаас дэлхийн аж үйлдвэр хөгжсөн бусад орнууд зөвхөн түүхий эдийг нь худалдан авахыг эрмэлзэх болсон.
2. Хоёр улсын хооронд өмнө нь тогтсон аж ахуйн болон үйлдвэрлэлийн хэлхээ, холбоо, бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн сүлжээ задарсан.
 3. ОХУ-ын Гаалийн тарифын тухай хууль болон Гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаал, Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа хөгжиж байгаа орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифын 75 хувийг ногдуулж үүнд манай улсын гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүн хамрагдах болсоноор манай бараа чөлөөтэй ОХУ-ын зах зээл рүү нэвтрэх боломж нь хаагдсан.
 4. ОХУ-аас манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүнүүдэд оногдуулж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн тарифын болон тарифын бус хязгаарлалт, тээврийн өндөр зардал,
 5. 1990 оноос эхлэн хоёр улс хоёулаа худалдааны хувьд дэлхийн аль л ашигтай гэж үзсэн улс орнуудтай чөлөөт худалдааг хийх болсон, өөрөөр хэлбэл гадаад худалдаандаа девирсификаци хийсэн.

Хэдийгээр манай хоёр орон шилжилтийн хүнд хэцүү үеийг даван туулж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн уламжлалт харилцааг сэргээх талаар ихээхэн идэвхи санаачлага гарган Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг тогтмол хийж эрх зүйн зохих баримт бичгүүдэд гарын үсэг зурсан ч хоёр орны хоорондын худалдаанд дорвитой өөрчлөлт одоохондоо алга байна.

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа нь орон нутгийн түвшин рүү шилжиж байна. Үүний жишээ бол манай улстай хиллэдэг ОХУ-ын субъектуудтэй хийж байгаа худалдааны эргэлт хоёр улсын худалдааны эргэлтийн 80-аад хувийг эзлэж байна. Зөвхөн Эрхүү мужтай хийж байгаа худалдааны эргэлт нийт худалдаанд 50.2 хувийг эзлэж энэ байдал нь цаашид ч үргэлжлэх хандлагатай байна. Үүнийг газар нутгийн хувьд байршил ойрхон учир тээврийн болон бусад зардал бага, Сибирийн ард түмэн манай улсын бараа, бүтээгдэхүүнийг сайн мэдэж хэрэглэх дуртай байдагтай холбон тайлбарлаж болно. Зураг 2-оос харна уу.

Зураг 2.




Манай улсын экспортын барааны өрсөлдөх чадвар маш хязгаарлагдмал, түүхий эд давамгайлсан өрөөсгөл бүтэцтэй байдаг. 2010 оны байдлаар манай нийт эскпортын 56.3 хувийг эрдэс бүтээгдэхүүн буюу хайлуур жонш эзлэж байгаа нь бусад орны түүхий эдийн хавсрага болох магадлал өндөр улс орны тоонд нэгэнт багтжээ. Мөн онд ОХУ руу хийсэн нийт эскпортын 22,6 хувийг адууны мах, 10 хувийг үхрийн хөлдөөсөн мах эзлэж нийт эскпортын 89,5 хувийг түүхий эд ба анхан шатны боловсруулалтай түүхий эд эзлэж байгаа манай эскпортын гол барааны боловсруулалтын түвшин маш доогуур байна. Үүнд 2010 оны 4 сарын 15-наас Монгол Улсын 9 аж ахуйн нэгжээс нэмүү өртөг шингэсэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн болох махан бүтээгдэхүүн импортлох шийдвэрийг ОХУ-ын мал эмнэлэг, хорио цээрийн албанаас гаргасан нь маш чухал ач холбогдолтой болж байна. Зураг 3,4-өөс харна уу.

Зураг 3.



Зураг 4.



Харин нэмүү өртөг шингэсэн эцсийн хэрэглээний уламжлалт бараа, бүтээгдэхүүн өчүүхэн бага 1.4 хувийг эзэлж байна. Монголын уламжлалт экспортын бараа гэдэгт мал, амьтны гаралтай бүх төрлийн бараа бүтээгдэхүүн, ангийн үс, ноос, ноолуураар хийсэн гоёлын болон өдөр тутмын хувцас, хивс, эсгий бүтээгдэхүүнийг (өөрөөр хэлбэл нийлэг эдийн хольцгүй, байгалийн гаралтай, экологийн цэвэр, натурал бүтээгдэхүүнийг) ойлгож болно. Хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 1. Монгол Улсын экспортод уламжлалт бараа бүтээгдэхүүний эзлэх хувь (сая ам.доллар)

| д/д | Он | 1993 | 1995 | 1997 | 1998 | 2000 | 2004 | 2006 | 2007 | 2008 | 2010 |
|-----|---------------------------|-------|------|------|------|------|------|------|------|------|------|
| 1 | Нийт экспортын бараа | 145,2 | 68,9 | 46,6 | 40,6 | 45,1 | 20,6 | 45,1 | 58,5 | 86,3 | 79,1 |
| 2 | Уламжлалт экспортын бараа | 13,56 | 2,62 | 0,70 | 0,16 | 0,73 | 0,63 | 1,07 | 1,01 | 1,24 | 10,9 |
| 3 | Хувийн жин (хувиар) | 9,3 | 3,8 | 1,5 | 0,39 | 1,6 | 3,05 | 2,3 | 1,7 | 1,4 | 1,4 |

Эх уулав: Монгол Улсын статистикийн хорооны эмхэтгэл 1993-2010, Гаалийн Ерөнхий газрын статистикийн эмхэтгэл 1994-2010

2010 оны байдлаар Монгол Улсын нийт импортод 59,9 хувийг авто бензин, дизелийн түлш, онгоцны түлш, мазут болон бусад нефтийн бүтээгдэхүүн эзлэж байгаа стартегийн хувьд ОХУ-аас хэт их хамааралтай байна. Импортын 2,2 хувийг улаан буудай болон улаан буудайн гурил, 1,4 хувийг цахилгаан эрчим хүч, 25 гаруй хувийг хөдөө аж ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж эзлэж байна. Хүснэгт 3-аас харна уу.

Хүснэгт 2. Монгол Улсын зарим барааны импортын бүтэц (сая доллар)

| | 2005 | | 2006 | | 2007 | | 2008 | | 2009 | | 2010 | |
|-------------------------|-------|-------|-------|-------|-------|-------|---------|-------|-------|-------|---------|-------|
| Импорт | 417,9 | 100.0 | 547,7 | 100.0 | 745,0 | 100.0 | 1,242,2 | 100.0 | 772,8 | 100.0 | 1,090,2 | 100.0 |
| Нефтийн бүтээгдэхүүн | 255,8 | 61.2 | 378,0 | 69.0 | 518,8 | 69.6 | 831,75 | 67.0 | 488,2 | 63.2 | 652,8 | 59.9 |
| Улаан буудайн гурил | 15,2 | 3.7 | 14,0 | 2.6 | 22,8 | 3.1 | 40,1 | 3.2 | 26,7 | 3.5 | 11,8 | 1.1 |
| Улаан буудай | 5,3 | 1.3 | 1,7 | 0.3 | 6,2 | 0.8 | 53,6 | 4.3 | 18,9 | 2.4 | 11,6 | 1.1 |
| Цахилгаан эрчим хүч | 5,5 | 1.3 | 6,5 | 1.2 | 6,2 | 0.8 | 7,8 | 0.6 | 6,1 | 0.8 | 14,7 | 1.4 |

*Эх үүсвэр: Гаалийн Ерөнхий газрын
статистикийн эмхэтгэл 1994-2010*

Олон улсын жишгээр стратегийн бүтээгдэхүүний хэрэглээнд импортоор авч буй барааны эзлэх хувь /нефть 35 хувь, гурил 30 хувь/ өндөр байх, тодорхой бүтээгдэхүүний 20-иос дээш хувийг зөвхөн нэг улсаас импортлодог бол уг орон тэр орноос эдийн засгийн хараат болсон гэж үздэг ажээ. Зураг 5-аас харна уу.

Зураг 5.



**Монгол Улс, ОХУ-ын худалдааны гол нэрийн
барааны хамаарлын шинжилгээ**

Хүснэгт 3. Экспорт

| | Монгол Улсын нийт экспортын хэмжээ | ОХУ руу оруулж буй экспорт | Жонш | мах махан бүтээгдэхүүн |
|------------------------------------|---------------------------------------|----------------------------------|-----------|---------------------------|
| Монгол Улсын нийт экспортын хэмжээ | 1 | | | |
| ОХУ руу оруулж буй экспорт | 0.77514661 | 1 | | |
| Жонш | 0.923555713 | 0.748114628 | 1 | |
| мах махан бүтээгдэхүүн | 0.730312123 | 0.814934277 | 0.6298438 | 1 |

Корреляцийн шинжилгээний дүнгээс харахад манай улсын ОХУ-тай хийж байгаа гадаад худалдаа хайлуур жоншны экспортоос 92 хувийн хамааралтай байна. Харин мах махан бүтээгдэхүүний экспортоос 73 хувийн хамааралтай болохыг харж болно. Эөвхөн энэ 2 төрлийн бараа ОХУ руу оруулж байгаа нийт экспортын 89,5 хувийг эзлэж байна.

Хүснэгт 4. Импорт

| | Монгол Улсын нийт импортын хэмжээ | ОХУ-аас оруулж буй импорт | Нефтийн бүтээгдэхүүн | Улаан буудайн гурил | Цахилгаан эрчим хүч |
|-----------------------------------|---|---------------------------------|-------------------------|---------------------------|------------------------|
| Монгол Улсын нийт импортын хэмжээ | 1 | | | | |
| ОХУ-аас оруулж буй импорт | 0.996085487 | 1 | | | |
| Нефтийн бүтээгдэхүүн | 0.982580798 | 0.993552965 | 1 | | |
| Улаан буудайн гурил | 0.759172138 | 0.803594495 | 0.8361074 | 1 | |
| Цахилгаан эрчим хүч | 0.694728511 | 0.640979693 | 0.5842985 | 0.105654 | 1 |

Монгол Улсын дэлхийн бусад улсуудаас оруулж нийт импортын хэмжээ нь ОХУ-аас оруулж байгаа импортоос 99 хувь, түүн дотороо нефть бүтээгдэхүүнээс 98 хувийн хамааралтай байгаа нь манай улс ОХУ-аас авч байгаа импортоос ихээхэн өндөр хамааралтай байгааг илтгэж байна.

**II. Хоёр талын худалдаанд оршиж
байгаа зарим асуудлууд**

ОХУ-ын Гаалийн тарифын тухай хууль болон Гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны тушаалын дагуу ОХУ импортын бараанд ногдуулж буй гаалийн тарифын шатлалыг дараах байдлаар тогтоохоор заасан. Үүнд:

- ОХУ-аас худалдааны нэн таатай нөхцөл олгож буй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг ногдуулдаг.

- ОХУ-аас нэн таатай нөхцөл олгоогүй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифыг 2 дахин нэмж ногдуулдаг.
- ОХУ-аас Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа хөгжиж байгаа орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татварын үндсэн тарифын 75 хувийг ногдуулдаг. Монгол Улс нэн тааламжтай нөхцөл болон хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгох хөгжиж буй орнуудын жагсаалтад багтаж байгаа болно.
- ОХУ-аас Хөнгөлөлтийн ерөнхий системийн дагуу тусгай хөнгөлөлт олгож байгаа нэн буурай хөгжилтэй орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй. ТУХН-ийн болон ЕАЭЗХН-ийн орнуудаас гарал үүсэлтэй импортын бараанд гаалийн татвар ногдуулдаггүй.
- ОХУ, Беларусь, Казакстан улсууд гаалийн холбоо байгуулснаар хоорондоо гаалийн татвараа тэглэж, гуравдагч орнуудтай хийх гадаад худалдаандаа гаалийн нэгдсэн бодлого явуулахаар болж байгаа бөгөөд үүнтэй холбоотой “ОХУ-ын гаалийн зохицуулалтын тухай хууль”-ийг баталж, 2010 оны 7 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчлэж эхэлсэн.

ОХУ импортын гаалийн татварыг тогтоохдоо тухайн барааны боловсруулалтын түвшинг харгалзан тогтоодог. Тухайлбал, голчлон түүхий эдэд 0-5, хагас боловсруулсан бүтээгдэхүүнд 5-15, бэлэн бүтээгдэхүүнд 15-30 хувь байдаг.

Манай улсын импортын бараанд энэхүү үндсэн тарифын 3.75-22,5 хувийг оногдуулж, үүн дээр НӨАТ-ын 18 хувийг нэмэхэд 26,25-40,5 хувь болж байна. Түүнээс гадна ОХУ-ын нутаг дэвсгэр дээр төмөр замаар тээвэрлэх дотоодын нэгдсэн тариф 10,9 хувь байдаг учир манай барааны үнэ нийтдээ 37,15-51,4 хувь болж өсөж байна. Энэ байдал нь манай экспортын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх болж, тэдгээрийн өрсөлдөх чадварыг бууруулж, тэдгээрийн нэр төрлийг олшруулахад саад учруулж байна.

Энэ байдал нь манай экспортын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх болж, тэдгээрийн өрсөлдөж чадварыг бууруулж, тэдгээрийн нэр төрлийг олшруулахад саад учруулж байна.

ОХУ-аас дээр дурьдсан тарифын зохицуулалтаас гадна тарифын бус хориг саадыг тавьсаар байна. Үүнд:

- Манай улсаас оруулж байгаа махыг зөвхөн ОХУ-ын ариун цэвэр хорио цээрийн хяналтын байгууллагын хяналтан дор

стандартын дагуу Улаанбаатар, Дархан, Багахангай мах комбинатуудад бэлтгүүлдэг,

- Зөвхөн Сүхбаатар-Наушкийн хилийн боомтоор,
- Зөвхөн төмөр замын тээврээр оруулахыг зөвшөөрдөг,
- Импортын мах, махан бүтээгдэхүүний лиценз, зөвшөөрлийг зөвхөн Москвагаас олгодог гэх мэт.

III. Дүгнэлт

ОХУ-ын зүгээс тарифын болон тарифын бус хориг саадыг зөвхөн манай улсын экспортын бараанд тавьдаг бус бусад улсуудын гарал үүсэлтэй бүх бараанд адил тэнцүү тавьж байна. ОХУ одоохондоо ДХБ гишүүнээр элсээгүй учир тарифын болон тарифын зохицуулалтыг ашиглан дангаараа зохицуулах эрхтэй байдаг. Иймд манай улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай алхаагаа нэгтгэн Америкийн эрдэмтэн П.Ромерын мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлж, ялангуяа хүн ардаа хөгжүүлэх, тэдний мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлж, үндэсний боловсруулах үйлдвэрүүдэд техник, технологийн инновацийг нэвтрүүлэхэд онцгой анхаарч ажиллах хүч, түүхий эд, эрчим, хүч, технологийн хангалт нийлүүлэлтийн найдвартай сувгийг бий болгоход шаардлагатай дэд бүтцийн (тээвэрлэлт, хадгалалт борлуулалт) сүлжээг байгуулж аж үйлдвэрийн кластерийг байгуулах замаар экспортын барааныхаа өрсөлдөж чадварыг дээшлүүлж улмаар үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэж аж үйлдвэрийн кластерийг байгуулах тохиолдолд дээр дурьдсан тарифын болон тарифын бус хориг саад тийм ч том асуудал биш байсан байж олох юм.

IV. Санал

- Манай улс мэдлэгийн эдийн засагт тулгуурлан экспортын барааны бүтцэд өөрчлөлт оруулах замаар боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж зөвхөн ОХУ бус дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг сайжруулах
- Худалдаанд оногдуулж байгаа тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах талаарх өмнө хийж байсан хэлэлцээрийг үргэлжлүүлж эрчимжүүлэх,
- Монгол Улсад шинээр тавих ашигт малтмалын томоохон орд газруудыг холбосон төмөр замын болон дэд бүтцийн сүлжээг барихад ОХУ-ын компаниудыг оролцуулах,
- Монгол малыг эрүүлжүүлэх үржил селекцийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр системтэй хийхэд ОХУ-тай хамтарч ажиллах,

- Хил орчмын болон бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, (Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт худалдааны бүсийг байгуулахад ОХУ-ын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах)
- Хил орчимд мал аж ахуйн түүхий эд боловсруулах хамтарсан үйлдвэрийг байгуулах

Ашигласан материал

1. Монгол Улсын Гаалийн тухай хууль 2008 оны 05 сарын 20 өдөр
2. Монгол Улсын Гаалийн тариф, татварын тухай хууль 2008 оны 05 сарын 20 өдөр
3. ОХУ-ын Гадаад худалдааны үйл ажиллагаан дахь төрийн зохицуулалтын тухай хууль, 2003 он
4. ОХУ-ын Гаалийн тарифын тухай хууль, 1993 он
5. ОХУ-ын Гаалийн тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай, Гаалийн улсын хорооны даргын тушаал, 2003 он
6. ОХУ-ын Эрхүү мужийн Гаалийн хорооны эмхэтгэл 1992-2010
7. Монгол Улсын статистикийн хорооны эмхэтгэл 1993-2010,
8. Гаалийн Ерөнхий газрын статистикийн эмхэтгэл 1994-2010
9. An Inquiry into the Nature and Causes of the Wealth of Nations, by Adam Smith. London: Methuen and Co., Ltd., ed. Edwin Cannan, 1904. Fifth edition.
10. Ricardo, D., [1817], *Principles of Political Economy and Taxation*, vol. i, p. 6, in: Sraffa (ed.), 1951, *The Works and Correspondence of David Ricardo*, 10 vol. (1951– 55), Cambridge: Cambridge University Press.
11. Friedman, Milton (November 15, 2002). *Capitalism and Freedom*. University of Chicago Press. ISBN 0226264211.
12. *Competitive Advantage of Nations*. — New York: Free Press, 1990 (2nd. ed. — New York: Free Press, 1998. — 896 p.
13. *Science, Economic Growth and Public Policy*, 1996 Paul Michael Romer

(Товчлон нийтлэв)